

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ГАЗАР ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ. КАДАСТРЫН НЭГЖ ТАЛБАРЫН ОРОН ЗАЙН
ӨГӨГДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

MNS : 2021

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР
2021 он

ӨМНӨХ ҮГ

Стандарт, Хэмжил Зүйн Газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг.

Энэхүү стандартыг Монгол Улсын Засгийн газраас Үндэсний орон зайн өгөгдлийн талаар баримталж буй үзэл баримтлал, хөтөлбөрийн хүрээнд орон зайн өгөгдлийг цахимжуулах нэгдсэн систем бүхий геопорталын орон зайн өгөгдөл бүрдүүлэлт, солилцоотой холбоотой стандартын орчныг бий болгоход зориулсан өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлагыг энэхүү баримт бичигт тусган боловсруулав.

Стандарт боловсруулах ажлыг “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” сэдэвт төслийн хүрээнд стандарт боловсруулалтын багийн доктор Б.Баяртунгалаг, доктор Б.Сайнбуян, С.Амаржаргал, З.Нямбаяр, мэргэшсэн инженер Э.Алтанбагана, Г.Бадамгарав, мэргэшсэн инженер Ц.Наранцацрал нар хамтран гүйцэтгэв. Сэлэнгэ аймгийн Газрын албаны эдэлбэр газрын кадастр, газар зохион байгуулагч М.Мөнхсоёл редакц хийж, Хөдөө аж ахуйн их сургуулийн Газрын менежментийн тэнхимийн эрхлэгч, Монгол улсын зөвлөх инженер, доктор, профессор Д.Түвшинбаяр шүүмжийг хийв.

Стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хамт олон, Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны гишүүд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон бусад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн мэргэжлийн байгууллагын хамт олонд талархал илэрхийлье.

Энэ стандартын төслийг ТХ-36/Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

Уг стандартыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006–ийн дагуу хянаж, боловсруулав.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар хот 13348 ШХ-48

Утас: (976-51) 263860

Факс: (976-11) 458032

Цахим шуудан: standardinform@masm.gov.mn

Цахим хуудас: www.estandart.gov.mn,

www.masm.gov.mn

СХЗГ 2021

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын Төв байгууллага) -т байна.

АГУУЛГА

ОРШИЛ.....	3
1 Хамрах хүрээ.....	4
2 Норматив эшлэл	4
3 Нэр томъёо, тодорхойлолт	4
3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт.....	5
3.2 Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт	6
4 Техникийн шаардлага	7
4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага	7
4.2 Атрибутад тавигдах (норматив) шаардлага	9
4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага	10
4.4 UML диаграмм (норматив) шаардлага	10
4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага	10
A хавсралт - Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга.....	11
B хавсралт - Кодын жагсаалт	24
C хавсралт - UML диаграмм	38
D хавсралт – Өгөгдлийн чанар.....	42

ОРШИЛ

Энэхүү стандартын зорилго нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг нэгдсэн мэдээллийн системд оруулах, бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, солилцох үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн сангийн бүтэц, агуулга, техникийн шаардлагыг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм.

Стандартыг баримталсны үр дүнд геопорталаар дамжуулан байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх, эрчимтэй хөгжих боломжийг олгоно.

Энэхүү стандарт нь нэг талаас орон зайн өгөгдлийн санг хариуцагч байгууллага нөгөө талаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй хамаарал бүхий үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, хадгалах, солилцох бүх харилцаанд үйлчилж нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах үндсэн баримт бичиг болно.

Стандартын техникийн шаардлагуудыг Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах Европын орон зайн мэдээллийн дэд бүтэц INSPIRE (Infrastructure for Spatial Information in Europe) системийн техникийн тодорхойлолт, олон улсын стандартын байгууллага (ISO)-ын TX 211 (ISO/TC 211-Geographic information/Geomatics) -с гаргасан ISO 19100 цуврал стандартуудын үзүүлэлт, шаардлагад тулгуурлаж, Монгол Улсад мөрдөж буй стандарт, норм, дүрэм, журам, орон зайн суурь өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэл болгон боловсруулав.

Мөн орон зайн суурь өгөгдлийн техникийн шаардлагуудыг мэдээллийн сангийн загварыг дүрслэх Загварчлалын Нэгдмэл Хэл (UML-Unified Modeling Language) -ийн дагуу нийцүүлэн боловсруулав.

Стандарт бүтэц нь орон зайн өгөгдлийн загвар, өгөгдлийн сангийн агуулга, орон зайн объектын төрөл, атрибут, кодын жагсаалт, UML диаграммаас бүрдэнэ.

Уг стандарт нь кадастрын нэгж талбарын орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, тайлагнах, үйлчлэх зорилгоор өгөгдлийг системтэй, уялдаатай болгон бүрдүүлэхэд чиглэнэ.

Кадастрын нэгж талбарын орон зайн өгөгдөлд газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгийн байршил, хил зааг, талбай, эзлэхүүн, тоо хэмжээ, төлөв байдал, чанарын болон эдийн засгийн үнэлгээ, төлбөр, тэдгээрийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн эрхтэй холбоотой мэдээллийг агуулна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 35.240.70

Газар зүйн мэдээлэл. Кадастрын нэгж талбарын орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS ... 2021
Geographic information. Data specification on Cadastral parcels	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны дугаар сарынний өдрийн дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь батлагдсан өдрөөс эхлэн хүчинтэй.

Стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Кадастрын нэгж талбарын орон зайн суурь өгөгдлийн сан нь өмчийн үндсэн нэгж, кадастрын хил, кадастрын бүс, кадастрын бүсийн ангилал, кадастрын нэгж талбар тэдгээртэй холбоотой мэдээллээс бүрдэнэ.

Энэхүү стандарт нь кадастрын нэгж талбарын орон зайн суурь өгөгдлийн сангийн бүтэц, стерео төрлүүд, атрибут мэдээллийн шаардлага, UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language), өгөгдлийн чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлоход хамаарна.

Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд кадастрын нэгж талбарын орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, хөтлөх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжид хамаарна.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO 19107, 2005, Газар зүйн мэдээлэл – Орон зайн схем;

ISO 19108, 2005, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем;

ISO 19108-с, 2002/Cor 1: 2006, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем, Техникийн засвар 1;

ISO 19111,2007, Газар зүйн мэдээлэл – Солбицлоор илэрхийлэгдсэн оронзайн дүрслэл;

ISO 19118: 2006, Газар зүйн мэдээлэл – Кодлолт;

ISO 19135, 2005 Газар зүйн мэдээлэл-Бүртгэлийн явц;

MNS ISO/TS 19104:2012 Газар зүйн мэдээлэл - Нэр томьёо;

MNS 5774:2007 Газар зүйн мэдээлэл – Мета өгөгдөл

MNS 6702: 2017 Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг

Масштаб: 1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандарт ба түүнд холбогдох бусад стандартын хувьд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

Үндсэн агуулгад хамаарах ойлголт

3.1.1

орон зайн өгөгдөл

газрын гадарга дээрх болон доорх, ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил зааг, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогц

3.1.2

орон зайн суурь өгөгдөл

харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх, оролцогч талуудын хэрэгцээг нийтлэгээр хангах боломжтой, үндсэн буюу голлох мэдээлэл гэж тодорхойлсон орон зайн өгөгдөл

3.1.3

өгөгдлийн багц

өгөгдлийн сангийн нэг сэдэвчилсэн агуулгын хүрээнд багтах хэд хэдэн өгөгдлийн цуглуулга.

3.1.4

стерео төрөл

стандартад ашиглаж байгаа биет болон атрибутын ижил төстэй шинж чанарыг харгалзан үүсгэсэн ангилал, төрлийг.

3.1.5

өгөгдөл төрөл

ямар нэгэн геометр дүрслэл агуулаагүй, өгөгдлийн сэдэвчилсэн утга, хэмжээс, формат зэргийг илэрхийлэгч, хэд хэдэн үзүүлэлтүүдийг агуулсан төрлийг.

3.1.6

биет төрөл

орон зайн агуулга бүхий геометр биетээр дүрслэгдсэн болон дүрслэх боломжтой биетийг илэрхийлэгч төрөл.

3.1.7

мета өгөгдөл

орон зайн өгөгдлийг хайх, бүртгэх, ашиглахад зориулагдсан орон зайн өгөгдлийн тухай мэдээллийн цогц (өгөгдлийн тухай өгөгдөл).

3.1.8

кодын жагсаалт

биетийн төрөл эсвэл өгөгдлийн төрлийн атрибутаг ашиглах урьдчилан боловсруулж үүсгэсэн ангиллын утгын жагсаалт.

3.1.9

домэйн

Тухайн сэдвийн үзүүлэлтийн агуулгын хүрээг илэрхийлнэ. Тухайлбал, хэмжээс /measure/ заасан утгын төрөлд “хэмжсэн тоон утга” байх ёстой гэсэн шалгуур нь домэйн болно.

3.2

Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт

3.2.1

Area

Тухайн талбайн хавтгай эсвэл объектын гадаргуугийн эзэлж буй орон зайн хэмжээ. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.2

Character string

Тэмдэгтийн мөр. Бичиглэхэд ашигладаг тэмдэгтүүдийн жагсаалт. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.3

Date time

Цаг хугацааг заасан утгын төрөл. Огноо, цагийн хослол хэлбэрээр байна. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.4

Localised character string

Тухайн улс эсвэл орон нутгийн хэлээр бичигдсэн, тэмдэгтээр илэрхийлсэн мэдээлэл. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19139:2007]

3.2.5

Measure

Хэмжилтийн үр дүнд гаргасан хэмжигдэхүүний тоон утга. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.6

Decimal

Аравтын бутархайгаар илэрхийлэгдсэн бутархай тоон утга. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.7

Integer

Тоон мэдээллийн хуваагдаагүй, задгай нэгж ашиглаагүй бүхэл утга байна. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.8

GM_Curve

Тасралтгүй холбогдсон, муруй хэлбэрийн шугаман дүрслэл. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

3.2.9

GM_MultiSurface

Олон гадаргуу бүхий геометр биет. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

3.2.10

GM_Point

Цэг бол зөвхөн нэг цэгээс бүрдэх геометр объектын өгөгдлийн үндсэн төрөл юм. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

3.2.11

GM_Polygon

Суурийн гадаргуу болон түүнийг хүрээлэх хил заагаар тодорхойлогдох гадаргуугийн цогц юм. [Дэлгэрэнгүй мэдээллийг ISO 19107:2003]

3.2.12


GM_MultiPolygon

Суурийн гадаргуу болон түүнийг хүрээлэх хил заагаар тодорхойлогдох гадаргуугийн олон талт цогц юм. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

4 Техникийн шаардлага

4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага

4.1.1 Орон зайн өгөгдлийн сан нь өгөгдлийг сэдэв, агуулгаас хамааруулан багцалсан хэлбэр болох “**өгөгдлийн багц**”, өгөгдлийн багц дотор агуулагдах стерео төрлүүд, өгөгдөл тус бүрийн дэлгэрэнгүй “**атрибут**”, атрибутад орох мэдээллийг төрөлжүүлж ангилсан “**кодын жагсаалт**” гэсэн хэсгүүдээс тогтсон бүтэцтэй (1-р зурагт тоймлон үзүүлэв) байхыг шаардана.



1-р зураг – Кадастрын нэгж талбарын өгөгдлийн сангийн бүтэц, агуулга

4.1.2 А хавсралтаар орон зайн өгөгдлийн сангийн багц тус бүрээр биет төрлүүд тэдгээрт хамаарах өгөгдөл төрөл, биет төрөл болон өгөгдөл төрлийн атрибут, атрибутын талбарт оруулах утга болон утгын төрлийн норматив шаардлагыг заана.

4.1.3 В хавсралтаар кодын жагсаалтын норматив шаардлагыг тодорхойлно. Кодын жагсаалт нь атрибутын талбарт оруулах утгад ашиглах тогтмол утга бүхий ангилал гэж ойлгоно.

4.1.4 Орон зайн өгөгдлийн сангийн багцад орсон өгөгдөл нь А хавсралтын А.1-р хүснэгтэд үзүүлсэн «биет төрөл», «өгөгдөл төрөл», «кодын жагсаалт» гэсэн стерео төрөлтэй байх норматив шаардлагыг хангана.

4.1.5 Биет төрөл тус бүрийн орон зайн дүрслэлийг А хавсралтын А.1-р хүснэгтэд “Биетийн төрөл” баганад үзүүлсэн шаардлагын дагуу дүрсэлнэ.

4.1.6 Өгөгдлийн нэрийг монгол, англи хэлээр нэрлэх бөгөөд мэдээллийг бүрдүүлэхдээ тодорхойлолтоор илэрхийлсэн агуулгын дагуу байхыг шаардана.

4.1.7 Кадастрын нэгж талбарын орон зайн суурь өгөгдлийн сан нь А хавсралтын А.1-р хүснэгтийн дагуу **кадастрын нэгж талбар** гэсэн 1 өгөгдлийн багцаас бүрдсэн байна.

4.1.8 Кадастрын нэгж талбарын орон зайн өгөгдлийн санд 6 биет төрөл, 6 өгөгдөл төрөл агуулна.

4.2 Атрибурад тавигдах (норматив) шаардлага

4.2.1 Өгөгдлийн атрибут мэдээлэл нь өгөгдөл тус бүрээр А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсэн норматив шаардлагыг хангана.

4.2.2 Атрибут нь А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсний дагуу атрибутын нэрийг монгол, /англи хэл/-ээр нэрлэх, “талбарт оруулах утга”, “утгын төрөл”, “тэмдэгтийн урт” гэсэн шаардлагыг хангахаас гадна тодорхойлолтод тусгасан мэдээллийн агуулгын дагуу бүрдүүлэлт, бичиглэлийг хийсэн байхыг шаардана.

4.2.3 Орон зайн өгөгдлийн сангийн биет төрөл нь давтагдашгүй гадаад танигч атрибутыг агуулах шаардлагатай. Гадаад танигч /External id/ нь орон зайн объектын танигч нь өгөгдлийн сангийн гадаад танигч үүсгэхэд ашиглах тусгай танигч код бөгөөд “дотоод танигч” /Local id/, “нэрийн талбар” /Name space/, “танигчийн хувилбар” /Version id/ гэсэн 3 атрибутаас бүрдэнэ [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005].

4.2.3.1 “Дотоод танигч /Local id/” нь тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байхыг шаардана.

4.2.3.2 “Нэрийн талбар /Name space/” нь өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

4.2.3.3 “Танигчийн хувилбар /Version id/” нь орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэсэн байхыг шаардана.

4.2.4 Кадастрын нэгж талбарын орон зайн суурь өгөгдлийн сан нь 4.2.4.1 -д заасан “Хаяг” /Address/ орон зайн дэд өгөгдлийн сантай холбогдоно.

4.2.4.1 “Хаяг” /Address/ нь тухайн нэгж талбарын “Хаягийн дүрслэл” /Address representation/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утгад «Хаягийн дүрслэл» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газар зүйн мэдээлэл. Хаягийн өгөгдлийн үзүүлэлт MNS:2021” стандартаас авч ашиглана.

4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага

4.3.1 А хавсралтын А.1-р хүснэгтэд кодын жагсаалтын тодорхойлолт, В хавсралтад кодын жагсаалтын кодын утга, түүний тодорхойлолтын дагуу норматив шаардлагыг хангана.

4.3.2 Кадастрын нэгж талбарын орон зайн өгөгдлийн санд 4 кодын жагсаалт агуулна.

4.3.3 А хавсралтын А.2 хүснэгтэд заасан атрибутын талбарт оруулах утгад заасан кодын жагсаалтын дагуу ангиллын утгыг сонгож оруулах нөхцөлөөр ашиглана.

4.4 UML диаграмм (норматив) шаардлага

4.4.1 Орон зайн объектын төрөл, атрибут, утгын төрөл, тэдгээрийн холбоосыг С хавсралтад үзүүлсэн UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language)-ын дагуу өгөгдлийг загварчилна.

4.4.2 Орон зайн өгөгдлийг загварчлах, боловсруулалтыг автоматжуулах, хэрэглээний схемд суурилсан өөр өөр түвшний өгөгдлийг уялдуулахад С хавсралтад үзүүлсэн UML диаграммыг ашиглана.

4.4.3 С хавсралтад үзүүлсэн UML диаграммаас гадна кадастрын нэгж талбарын орон зайн суурь өгөгдлийн сантай хамааралтай бусад орон зайн суурь өгөгдлийн сангийн UML диаграммыг ашиглахыг зөвшөөрнө.

4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага

4.5.1 Өгөгдлийн чанарт тавигдах шаардлага нь кадастрын нэгж талбарын суурь орон зайн өгөгдлийн нэгжийн чанарыг үнэлэх, баримтжуулах зорилготой чанарын элементүүдийн шаардлагыг D Хавсралтын D.1.1 - D.1.4-р хүснэгтэд үзүүлснээр дагаж мөрдөнө. Эдгээр шаардлага нь ISO 19157 олон улсын стандартад заасан чанарын үзүүлэлтүүд бөгөөд энэ стандартад ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөнө.

4.5.2 Кадастрын нэгж талбарын суурь орон зайн өгөгдлийн сангийн өгөгдлийн нэгж болох багц, биет төрөл, өгөгдөл төрлүүд нь өгөгдлийн чанарын дараах ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангана. Үүнд:

4.5.2.1 Иж бүрдэл: биет болон тэдгээрийн атрибут, харилцан хамаарлуудын түвшин.

4.5.2.2 Утга агуулгын нийцтэй байдал: өгөгдлийн бүтэц, атрибут ба харилцан хамаарлуудын логик дүрмүүдийг баримтлах түвшин.

4.5.2.3 Байрлалын нарийвчлал: орон зайн объектын байрлалын нарийвчлалын түвшин.

ТӨГСӨВ

А хавсралт
(норматив)

Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга

А. 1-р хүснэгт – Кадастрын нэгж талбарын орон зайн суурь өгөгдлийн багц ба стерео төрлүүд

А.1.1 Өгөгдлийн багц: Кадастрын нэгж талбарын суурь өгөгдөл (Cadastral parcels)

Дүд	Өгөгдлийн нэр	Стерео төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Өмчийн үндсэн нэгж <i>/Basic property unit/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Хууль тогтоомжоор тогтоосон өмчлөх эрхийн тухай үндсэн нэгж юм. Энэ нь нэг буюу хэд хэдэн зэргэлдээ нэгж талбараас эсвэл Газар зүйн хувьд тусдаа нэгж талбаруудаас бүрдэнэ. Газрын тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд эзэмшүүлэх, ашиглуулах зорилгоор олгосон газар.
2	Кадастрын нэгж талбар <i>/Cadastral parcel/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Кадастрт тусгагдаж тодорхой хил заагаар хязгаарлагдсан, ашиглалтын зориулалт, эзэмшигч, ашиглагч, өмчлөгч нь нэг, оноосон дугаартай эдлэн газар, объект буюу түүний хэсгийг хэлнэ.
3	Өргөдөл хүсэлт <i>/Request/</i>	«өгөгдөл төрөл» <i>/data type/</i>	-	Өргөдөл хүсэлтийн мэдээлэл.
4	Эрхийн мэдээлэл <i>/Permission/</i>	«өгөгдөл төрөл» <i>/data type/</i>	-	Эрхийн мэдээлэл.
5	Өмчлөгч, эзэмшигч <i>/Owner/</i>	«өгөгдөл төрөл» <i>/data type/</i>	-	Өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл.
6	Төлбөр <i>/Tax/</i>	«өгөгдөл төрөл» <i>/data type/</i>	-	Нэгж талбарын төлбөрийн мэдээлэл.
7	Суурь үнэлгээ <i>/Evaluation/</i>	«өгөгдөл төрөл» <i>/data type/</i>	-	Нэгж талбарын үнэлгээний мэдээлэл.

8	Зах зээлийн үнэ /Price/	«өгөгдөл төрөл» /data type/	-	Нэгж талбарын зэх зээлийн үнийн мэдээлэл.
9	Кадастрын хил /Cadastral boundary/	«биет төрөл» /feature type/	Полигон	Кадастрын нэгж талбаруудыг багтаасан ба өөр хоорондоо давхцалгүйгээр дүрслэгдсэн хил зааг.
10	Кадастрын бүс /Cadastral zoning/	«биет төрөл» /feature type/	Полигон	Эзэмшигч, ашиглагч, өмчлөгч нар нь газар ашиглалтын нийтлэг зориулалттай, ашиглалтын төрлийн хязгаарлалт бүхий хэсэг.
11	Газрын суурь үнэлгээ /Base evaluation/	«биет төрөл» /feature type/	Полигон	Газрын суурь үнэлгээ.
12	Газрын төлбөрийн бүс /Fee zone/	«биет төрөл» /feature type/	Полигон	Газрын төлбөрийн бүс.
13	Кадастрын бүсийн ангилал /Cadastral zoning value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Кадастрын бүсийн ангилал.
14	Кадастрын мужийн ангилал /Cadastral region value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Кадастрын мужийн ангилал.
15	Кадастрын тойргийн ангилал /Cadastral district value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Кадастрын тойргийн ангилал.
16	Төлбөрийн хугацаа /Payment date value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Төлбөр тооцож буй хугацааны ангилал.

А. 2-р хүснэгт - Орон зайн өгөгдлийн дэд сангийн давхаргын атрибутын агуулга

А.2.1 Өгөгдлийн багц – Кадастрын нэгж талбарын суурь өгөгдөл (Cadastral parcels)

А.2.1.1 Биет төрлийн нэр: Өмчийн үндсэн нэгж (Basic property unit)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Полигон /GM_Polygon/	-	-	Объектын орон зайн дүрслэлийг тодорхойлсон геометр.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Үл хөдлөх эд хөрөнгийн үндсэн нэгжийн бүртгэлийн албан ёсны /хууль ёсны дагуу байгуулагдсан/ огноо, цаг.
8	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Үл хөдлөх эд хөрөнгийн үндсэн нэгжийн бүртгэл хууль ёсны дагуу дуусгавар болсон /ашиглахаа больсон/ огноо, цаг.
9	Улсын бүртгэлийн дугаар /National cadastral reference/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Нэгж талбарын дугаар. Газрын улсын бүртгэлийн мэдээлэл эсвэл түүнтэй дүйцэх бүртгэлээр баталгаажсан мэдээлэл.

10	Талбай /Area value/	Талбай /Area/	Бутархай тоо /Decimal/	10	Үндсэн нэгжийг бүрдүүлэгч кадастрын нэгж талбарын хэвтээ хавтгайд дүрслэгдсэн талбайн (тоон хэмжээст шилжүүлэх) утга.
----	----------------------------	---------------	------------------------	----	---

А.2.1.2 Биет төрлийн нэр: Кадастрын нэгж талбар (Cadastral parcel)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Олон талт гадаргуу /GM_Multisurface/	-	-	Кадастрын нэгж талбарын геометр дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Кадастрын нэгж талбарыг бүртгэлийн системд оруулсан албан ёсны (хууль ёсны дагуу байгуулагдсан) огноо, цаг.
8	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Кадастрын нэгж талбарыг хууль ёсны дагуу цуцалсан, ашиглахаа больсон огноо, цаг.
9	Нэгж талбарын хаяг /Label/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт багцалсан объектын байрлалыг илэрхийлэх давхардаагүй үсэг болон тоон утга

10	Цэгийн лавлагаа /Reference point/	ГМ_Цэг /GM_Point/	-	-	Кадастрын нэгж талбарын хил заагийг үүсгэгч эргэлтийн цэгүүдийн байрлалын утга.
11	Талбай /Area value/	Талбай /Area/	Бутархай тоо /Decimal/	10	Үндсэн нэгжийг бүрдүүлэгч кадастрын нэгж талбарын хэвтээ хавтгайд дүрслэгдсэн талбайн (тоон хэмжээст шилжүүлэх) утга.
12	Улсын бүртгэлийн дугаар /National cadastral reference/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Нэгж талбарын дугаар. Газрын улсын бүртгэлийн мэдээлэл эсвэл түүнтэй дүйцэх бүртгэлээр баталгаажсан мэдээлэл.
13	Хаягийн дүрслэл /Address representation/	«Хаягийн дүрслэл» «Address representation»	-	-	Хаягийн орон зайн дэд өгөгдлийн сангийн “Хаягийн дүрслэл” өгөгдөл төрлийг авч ашиглана.

А.2.1.3 Өгөгдөл төрлийн нэр: Өргөдөл хүсэлт /Request/

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Өргөдлийн дугаар /Application number/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	30	Өргөдлийн дугаар.
2	Өргөдлийн огноо /Appliction date/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Өргөдлийн огноо.
3	Өргөдлийн төрлийн нэр /Appliction type name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өргөдлийн төрлийн нэр.
4	Өргөдлийн төрлийн код /Appliction type code/	Хэмжээс /Measure/	Бүхэл тоо /Integer/	10	Өргөдлийн төрлийн код.
5	Өргөдлийн явц /Appliction process/	Хэмжээс /Measure/	Бүхэл тоо /Integer/	10	Өргөдлийн явц.

А.2.1.4 Өгөгдөл төрлийн нэр: Эрхийн мэдээлэл /Permission/

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Эрхийн төрлийн код /Right type code/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Эрхийн төрлийн код.
2	Эрхийн төрлийн нэр	Тэмдэгтийн мөр	Тэмдэгтийн мөр	50	Эрхийн төрлийн нэр.

	/Right type/	/Character string/	/Character string/		
3	Хугацаа /Approved duration/	Хэмжээс /Measure/	Бүхэл тоо /Integer/	10	Хугацаа.
4	Шийдвэрийн дугаар /Decision number/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	30	Шийдвэрийн дугаар.
5	Шийдвэрийн огноо /Decision date/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Шийдвэрийн огноо.
6	Шийдвэрийн түвшний нэр /Decision level name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	80	Шийдвэрийн түвшний нэр.
7	Шийдвэрийн түвшний код /Decision level code/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Шийдвэрийн түвшний код.
8	Гэрчилгээний дугаар /Certificate number/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	30	Гэрчилгээний дугаар.

А.2.1.5 Өгөгдөл төрлийн нэр: Өмчлөгч, эзэмшигч /Owner/

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Регистрийн дугаар /Register number/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	30	Регистрийн дугаар
2	Овог нэр /оноосон нэр/ /Person name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Овог нэр /оноосон нэр/
3	Улсын бүртгэлийн дугаар /State number/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	30	Улсын бүртгэлийн дугаар
4	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ангилал /Administrative unit primary class/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн анхдагч ангилал /Administrative unit primary class value/	-	-	Субъектийн мэдээллийн газар зүйн байршлыг илэрхийлэх засаг захиргааны нэгжийн код. Хил заагийн орон зайн дэд өгөгдлийн сангийн Administrative unit primary class value - кодын жагсаалтын утгаас авч ашиглана.
5	Хаягийн дүрслэл /Address representation/	«Хаягийн дүрслэл» «Address representation»	-	-	Хаягийн орон зайн дэд өгөгдлийн сангийн “Хаягийн дүрслэл” өгөгдөл төрлийг авч ашиглана.

А.2.1.6 Өгөгдөл төрлийн нэр: Төлбөр /Tax/

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Газрын төлбөр /Land duty/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Газрын төлбөр. Нэг метр квадратын төлбөр /төгрөгөөр/.
2	Төлбөрөөс чөлөөлөх хувь /Discount percent/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Төлбөрөөс чөлөөлөх хувь.
3	Төлбөрөөс чөлөөлөгдөх дүн /Discount amount/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Төлбөрөөс чөлөөлөгдөх дүн /-төг/.
4	Гэрээнд ногдуулсан дүн /Fee calculated/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Гэрээнд ногдуулсан дүн /төг/.
5	Нөхөн төлбөр /Compensation amount/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Нөхөн төлбөр /төг/.
6	Хүү торгууль /Earning amount/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Хүү торгууль /төг/.
7	Газрын төлбөрийн зөрүү /Land duty difference/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Газрын төлбөрийн урьд оны илүү, дутуу /±төг/ зөрүү.
8	Жилийн төлбөр /Total payment/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Тайлант онд ногдуулсан жилийн төлбөр /төг/.
9	Төлбөрийн хугацаа /Payment date/	Төлбөрийн хугацаа /Payment date value/	-	-	Жилийн төлбөр төлөлтийн хугацаа. Payment date value – кодын жагсаалтын утгаас авна.
10	Татвар төлөгчийн дугаар /Tax id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	40	Татвар төлөгчийн дугаар.
11	Дутуу төлөлт /Remainning amount/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Урьд оны дутуу төлөлтөөс /төг/.
12	Хүү торгууль үлдэгдэл /Earning amount balance/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Хүү торгууль үлдэгдэл /төг/.
13	Бүгд дүн /Total amount/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Бүгд дүн /төг/.
14	Хүчингүй болсон дүн /Invalid amount/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Хүчингүй болсон дүн.
15	Илүү, дутуу төлөлт /Year amount/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Тайлант оны эцэст илүү дутуу төлөлт /төг/.

А.2.1.7 Өгөгдөл төрлийн нэр: Суурь үнэлгээ /Evaluation/

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Газрын суурь үнийн бүс /Level number/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Газрын суурь үнийн бүс.
2	Газрын суурь үнэ /Base price square/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Газрын суурь үнэ /1м2/.
3	Нэгж талбарын суурь үнэ /Base price/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Нэгж талбарын суурь үнэ.
4	Дуудлага худалдааны анхны үнийн итгэлцүүр /Confidence/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Дуудлага худалдааны анхны үнийн итгэлцүүр.
5	Дуудлага худалдааны анхны үнэ /Auction first price/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Дуудлага худалдааны анхны үнэ.

А.2.1.8 Өгөгдөл төрлийн нэр: Зах зээлийн үнэ /Price/

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Мэдээллийн ангилал /Category/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Мэдээллийн ангилал.
2	Мэдээллийн эх сурвалж /Description/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	150	Мэдээллийн эх сурвалж.
3	Мэдээллийн огноо /Status date/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Мэдээллийн огноо.
4	Газрын төрөл /Has property/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Газрын төрөл.
